

гоёж чимсэн, хэтэрхий товойлгосон маягаар хандаж болохгүй, тэгвэл зохиол бүтээлийн үзэл санаа, агуулгыг илэрхий бууруулна хэмээн зөв зүйтэй бичжээ. В. И. Лениний тухай болоод хувьсгалын сэдвүүд нь түүх-хувьсгалын бадрангуй хөгжил, монголын утга зохиолын чиг хандлагатай нягт уялдаатай юм. Иймд зохиолчдоос гагцхүү түүх-хувьсгалын тухай сэдвийн хөгжил дэх улс төр, түүх, гоо сайхны танин мэдэхүйг гаргах төдийгүй түүх, хувьсгалын үнэн, уран сайхны итгэл үнэмшлийг мөнхийн харилцаанд нь чадварлагаар дүрслэн харуулахыг гүнзгий шаардаж байна. Энэхүү сэдвүүд нь үнэнхүү амин чухал зүйл бүлгээ. Зөвлөлтийн монголч эрдэмтэн Л. К. Герасимович, Н.О. Шарак шинова, К.Н. Яцковская нар зохиогчийг судалгаа хийх хүртэл монголын уран зохиол дахь Лениний дүрийн судлалын гол зангилаа асуудлуудыг боловсруулсан юм. БНМАУ-д В. И. Ленинд зориулсан эмхэтгэлүүд хэвлэгдэн гарч¹, утга зохиол судлаач Ш. Цэнд-Аюуш утга зохиол дахь В.И. Ленин, Д. Сүхбаатар нарын дүрд зориулсан судалгааны зохиолоо хэвлүүлээ.² БНМАУ-д түүхийн утга зохиолын судлалыг улам бүр баяжуулж байгаа монголын утга зохиол дахь Лениний дүрийн судлалын хөгжлийн иймэрхүү замууд байна.

Оросоос орчуулсан **Ч. Эрдэнэбаяр**

**«БНХАУ ДАХЬ ҮНДЭСТНИЙ
ЗАРИМ АВТОНОМИТ РАЙОНЫ
БАЙДАЛ (1976—1983)»**

(Улаанбаатар - Прага 1987)
номын тухай танилцуулга

«БНХАУ дахь үндэстний зарим автономит районы өнөөгийн байдал (1976—1983) хэмээх нэгэн сэдэвт хамтын бүтээлийг БНМАУ-ын ШУА-ийн Дорнодахины судлалын хүрээлэн, БНСЧСУ-ын ШУА-ийн Дорнодахины хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтнууд хамтран бичив. Уг хамтын бүтээл нь БНХАУ-ын хятад биш үндэстнүүдийн талаар урьд өмнө бичиж хэвлүүлсэн судалгааны ном зохиолуудын үргэлжлэл болох юм.

Энэхүү номыг зохиогчид ХКН, Хятадын засгийн газраас үндэстний талаар явуулж ирсэн бодлого түүний мөн чанар, сүүлийн үед үндэстний бодлогод гарч буй зарим нэг өөрчлөлтийн асуудлыг БНХАУ-ын үндэстний 5 автономит районоос нэлээд томоохон нь болох, эрт дээр цагаас эхлэн манай улсын түүх, соёлын хөгжилтэй ямар нэг талаар холбоотой явж ирсэн Өвөрмонгол, Төвд, Синьцзян 3 районы улс төр, нийгэм-эдийн засаг, соёлын хөгжилтөөр харуулжээ.

Уг номын «Өвөрмонголын өөртөө засах орон» 1 хэсэгт, Өвөрмонгол нь БНХАУ-ын нэг автономит район болон зарлагдсан 1947

1 Ленин амьд бүхнээс амьд. Улаанбаатар, 1970, 253 тал Мөнх Ленин, Улаанбаатар, 1980, 150 тал
2 Утга зохиолд мөнхөжсөн Ленин, Сүхбаатар, Улаанбаатар 1977, 94 тал

оноос хойших тус районы засаг захиргаа, нутаг дэвсгэрт гарсан өөрчлөлт, энэ талаар хятадын удирдагчдын явуулсан бодлого, хэрэгжүүлсэн арга хэмжээнүүд нь монгол хүн амыг дарангуйлан устгахад чиглэгдэж байсан ба түүний эсрэг Өвөрмонголын ард түмэн хэрхэн тэмцэж байсан тухай; түүнчлэн Өвөрмонголын автономит районы нийгэм-эдийн засаг, соёлын хөгжилтийг салбар бүрээр тусгажээ. Энэ хэсгийн «ӨМӨЗО-ы засаг захиргаа, нутаг дэвсгэрийн өөрчлөлт» 1 бүлгийг түүхийн ухааны дэд эрдэмтэн Ч. Далай, эрдэм шинжилгээний ажилтан М. Зэнээ нар, «Монгол хүн амын талаар явуулсан бодлого», «Соёл эрүүлийг хамгаалах» П, IV бүлгүүдийг М. Зэнээ, «Эдийн засгийн товч тойм» III бүлгийг түүхийн ухааны дэд эрдэмтэн А. Дамдинсүрэн нар тус тус бичжээ.

Чехословакийн Дорнодахины хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан Л. Холоупкова Төвдийн нийгэм-эдийн засгийн хөгжлийн хоцрогдол, ард түмний аж амьдралын ядуу байдал, ХКН-аас тус районы хүнд хэцүү байдлыг богино хугацаанд арилгах үүднээс зарим нэг арга хэмжээ авч, шинэ Төвдийг байгуулах тусгай зорилт дэвшүүлж байгаа тухай «Төвдийн автономит район» П хэсэгт бичжээ. Ингэхдээ 1980 онд ХКН-аас ТАР-ы хувьд онцгой бодлого явуулах болсон үеэс өмнөх, түүнээс хойших үеийн байдлаар тус тусад нь салган харуулсан ба энэ нь уншигчдад Төвдийн тухайн үеийн байдлыг харьцуулж үзэхэд нэлээд дөхөм болсон байна. Түүнчлэн 1959 онд 80 мянган төвдүүдийн хамт Энэтхэгт дүрвэн гарсан Төвдийн шашны тэргүүн XIV Далай ламын талаар ХКН ямар бодлого баримталж байгаа болон Далай ламын өөрийн нь баримталж буй байр суурийн тухай сонирхолтой асуудлыг «Хилийн чанад дахь төвдүүд ба Далай ламын талаархи бодлого» хэмээх бүлэгт хөндөн бичсэн байна.

Номын «Синьцзян-Уйгурын автономит район» Ш хэсгийн «СУАР-ы улс төр, нийгэм-эдийн засгийн байдал» I бүлгийг эрдэм шинжилгээний ажилтан Л. Бэгэжав, «Синьцзян дахь хятад биш ард түмнүүдийн соёлын хөгжлийн зарим асуудал» II бүлгийг эрдэм шинжилгээний ажилтан М. Хурметхан нар тус тус бичжээ. Номын энэ хэсгээс тус автономит районы улс, төр, эдийн засгийн ерөнхий тойм, засаг захиргааны зохион байгуулалт, тус хязгаар нутгийг цэрэгжүүлж байгаа тухай мөн Синьцзяны ард түмний аж байдал, шинжлэх ухаан, боловсрол, эмнэлэг, үйлчилгээ, урлаг утга зохиолын хөгжилтийг багтаан харуулжээ.

Уг номонд 1976—1983 оны хоорондох үеийн байдлыг голлон харуулж бичсэн боловч урьд үеийн хэрэг явдлыг ор тас орхигдуулсангүй харин ч сүүлийн үеийн байдалтай нь холбон авч үзсэн байна. Энэ нь уншигчдад хятадын удирдагчдаас хятад биш үндэстний талаар урьд өмнө явуулж ирсэн бодлого эцэстээ ямар уршиг дагавар авчирсан тухай, түүнийг засварлан өөрчилж, үндэстний бодлогод уян хатан хандахаас өөр аргагүй байдалд хүргэсэн нөхцөл байдлыг нэлээд тод томруун гаргаж өгчээ.

Зохиогчид номоо 1976—1983 оны үйл явдал дээр тулгуурлаж бичсэн нь бас тохиолдлын хэрэг биш юм. Учир нь энэ хугацаанд тус орны хувьд нэлээд чухал үйл явдлууд болж өнгөрсөн билээ. 1976 онд БНХАУ ын олон жил толгойлж, Хятадын ард түмнийг удирдан чиглүүлэх жанжин шугамдаа элдэв завхруулга гаргаж байсан Мао Цзэдун нас эцэслэсэн төдийгүй улмаар түүний үзэл бодлыг баримтлагч хэсэг хүмүүс улс төрийн тавцнаас буув. Энэ нь тус орны гадаад, дотоод бодлогод, түүний дотор үндэстний бодлогод зарим нэг нааштай өөрчлөлт

ороход нөлөө үзүүлжээ. Түүнчлэн энэ хугацаанд хятадын удирдагчдаас өнөө хэрэгжүүлж байгаа гадаад, дотоод бодлогын чиг шугамыг үндсэнд нь тодорхойлсон ХКН-ын 11 дэх удаагийн Ш бүгд хурал, ХКН-ын XII их хурал, хуралдав. 80-аад оны эхээр үндэстний талаар явуулж ирсэн их хан үндэстний дээрэнгүй уусгах бодлого түүнд шүүмжлэлтэй хандах бодлогоор солигдож эхэллээ. Үндэстний районуудын нийгэм-эдийн засаг, соёлын салбарт зарим нэг өөрчлөлт ажиглагдах болов. Энэ бүхнийг зохиогчид бодит баримт материал дээр тулгуурлан үнэлэлт, дүгнэлттэй бичжээ.

ШУА-ийн Хэвлэх үйлдвэрээс эрхлэн хэвлэж саяхнаас худалдаанд гарч буй энэ бүтээл нь зөвхөн түүх, дорнодахин, хятад судлалын мэргэжлийн хүмүүст төдийгүй их дээд сургуулийн багш, окутан сурагчдад түүнчлэн уг асуудлыг сонирхогч бусад уншигчдад гарын авлага болохуйц ном болсон байна.

Л. Лхамдулам

**ШИГЭО ОЗАВА «КИНДАЙНО
МОНГОРҮ» (Орчин үеийн
Монгол) номын тухай Токио. 1978.**

Монголын судлалд багагүй хувь нэмэр оруулсан Токиогийн Гадаад хэлний дээд сургуулийн профессор, монголч эрдэмтэн Шигэо Озава манай оронд олон удаа ирж байсан ба Монголч эрдэмтний 5 их хуралд оролцсон хүн юм. Тэрээр монгол орноор явж байхдаа үзэж харсан, сонсож мэдсэн зүйлдээ болон өөрийн судалгааны ажилд тулгуурдан «Орчин үеийн Монгол» номоо бичжээ.

Энэ ном нь «Монголын үүрийн гэгээ», «Үлгэр домгийн Монгол орон», «Миний Монгол» гэсэн гурван бүлгээс бүрджээ.

Зохиогч энэ бүтээлдээ монголын ард түмний түүх, нийгэм улс төр, соёл шинжлэх ухааны ололт амжилт, монголчуудын зан заншил, монгол орны байгалийн гоо сайхан, малчдын амьдрал, монгол хэлний тухай голлон тусгаж, Япон-Монгол, Зөвлөлт-Монгол Хятад-Монголын харилцааны талаар өөрийн үзэл бодлоо цухас дурджээ.

Зохиогч. . Шинэ монголын нүүр царай нь шинэ хуучин хоёр ертөнцөд багтана. Нэг дэх нь Улаанбаатар хот бэлхнээ гэрчлэх нийслэлийн дүр төрх, хоёр дахь нь хангай говь хээр талын ертөнц юм. Энэ хоёроос «Орчин үеийн Монгол»-ыг эрж болно (50-р тал) гээд Улаанбаатар хотын түүх, хотын хөгжил цэцэглэлт, ололт амжилтыг дэлгэрэнгүй өгүүлжээ. . Хувьсгалаас өмнө эсгий гэр, сүм дуган, цөөн тооны модон байшин замбараагүй зэрэгцсэн хот байсан гэгдэх Хүрээ нь (55-р тал) шинэчлэгдэн өөрчлөгдөж орчин үеийн шинэ хот болсныг «нарны гэрэлд нүд гялбам цайран гэрэлтэх энэхүү хотыг «Гэрэлт хот» хэмээн нэрлэвэл илүү тохиромжтой (51-р тал) гэжээ.

Цааш нь: . Монгол орон малчдын орон байсныг эргэн тойрны эдгээр юмс үндсэндээ мартагдуулах мэт. Эртнээс нүүдлийн мал аж ахуй эрхэлж ирсэн малчин ардууд энэ сайхан хотыг барьж байгуулсан юм. Үүнд зөвлөлтийн тусламж ч бас бий (55-р тал) гээд шинэч-